



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 325

Улаанбаатар хот

Стратеги батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. “Эх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих стратеги”-ийг нэгдүгээр, “Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламжаас зохицуулах, дотоодын эх үүсвэрээс гаргах замаар жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газар (Р.Оюунханд), аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга, захирал нарт даалгасугай.

3. Стратегийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Оюунсүрэн)-т үүрэг болгосугай.

САЙД



ГШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081143

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 08 дугаар сарын 24 өдрийн 325 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих стратеги
(2015-2020)

Нэг. Үндэслэл, өнөөгийн байдал дэлхий дахинд ба Монголд, тулгамдаж буй асуудлууд

Бага насны¹ хүүхдийн бие бялдар, оюуны хөгжлийг бүрэн тэтгэж, эсэн мэнд амьдрах, цаашид урт удаан хугацаанд эрүүл саруул байлгах гол нөхцөл нь тэднийг амьдралын эхний үе шатнаас зөв зохистой хооллож, шимт бодисыг хэрэгцээт хэмжээгээр хангах юм. Хүний амьдралын эхний 1000 хоногт буюу эх жирэмсэлснээс эхлэн 2 нас хүртэлх хугацаанд хоол тэжээлийн дуталд өртөх нь хожмын эргэшгүй хүнд өөрчлөлт болох өсөлтийн хоцролтой болоход хүргэнэ. Хүнсний хүртээмж, тэжээллэг чанар муу байх, шим тэжээлийг шингээх чадамжгүй болох нь дэлхийн хүн амын нилээн хэсгийг хоол тэжээлийн дутал, аминдэм, бичил бодисын дутал, илүүдэл жин таргалалт, хүн амын бүлгийн ялгаатай байдлыг үүсгэж байна².

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн сангаас санаачлан бага насны хүүхдийн хооллолтын зөв дадлыг дэмжихэд улс орнуудын анхаарлыг хандуулах зорилгоор "Нялх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих дэлхийн стратеги"³-ийг боловсруулж, 2002 онд ДЭМБ-ын 55 дугаар чуулганаар баталсан. Нялх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих дэлхийн стратегид² "Эхийн сүү нь хүүхдийн бие махбодын хэвийн өсөлт, хөгжилтийг хангахад зориулагдсан төгс найрлагатай юугаар ч орлуулашгүй бүтээгдэхүүн болохоос гадна эхийн эрүүл мэндийн хамгийн чухал нөхөн үржихүйн үйл ажиллагааны салшгүй хэсэг мөн" гэж заасан ба ДЭМБ-ын зөвлөмжинд⁴:

- хүүхдийг эхээс мэндэлмэгц эхний нэг цагийн дотор буюу аль болох эрт ангир уургийг амлуулах;
- хүүхдийг 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох ба өөр ямар нэгэн сүү, тэжээл, ус зэргийг өгөхгүй байх;
- 6 сар хүрмэгц үргэлжлүүлэн хөхүүлэхийн зэрэгцээ аюулгүй, тохирсон нэмэгдэл хоолонд оруулах;
- хоёр ба түүнээс дээш насанд үргэлжлүүлэн хөхүүлэхийн зэрэгцээ тохирсон нэмэгдэл хоолоор хооллоно гэж заасан.

ДЭМБ-аас 2025 он гэхэд дэлхий нийтийн эх, нялх бага насны хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах төлөвлөгөөг 2012 онд баталж дараах зорилтуудыг дэвшүүлсэн⁵. Үүнд:

1. тав хүртэлх насны хүүхдийн өсөлтийн хоцролтыг 2010 оны түвшнээс 40 хувиар бууруулсан байх;

¹ Бага насны хүүхэд гэдэгт 3 хүртэлх насны хүүхдийг багтаана.

² Comprehensive Implementation Plan on Maternal, Infant and Young Child Nutrition. WHO. 2012

³ WHO/UNICEF. *Global strategy for infant and young child feeding*. Geneva, World Health Organization, 2003.

⁴ Essential nutrition actions: improving maternal, newborn, infant and young child health and nutrition. WHO. 2013

2. төрөх насны эмэгтэйчүүдийн дундах цус багадалтын түвшинг 50 хувиар бууруулах;
3. бага жинтэй төрөлтийн түвшинг 30 хувиар бууруулах;
4. тав хүртэлх насны хүүхдийн дундах илүүдэл жингийн түвшинг ихэсгэхгүй байх;
5. зургаан сар хүртэлх насны хүүхдийн эхийн сүүгээр дагнан хооллолтын үзүүлэлтийг 50 хувьд хүргэх;
6. тав хүртэлх насны хүүхдийн туранхайн үзүүлэлтийг 5 хувиас бага түвшинд байлгах;

Монголын хүүхдийн хоол тэжээлийн байдал

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монголын 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн дутлын үзүүлэлтүүд буурснаар хүн амын хоол тэжээлийн байдалд эерэг өөрчлөлт бий болсон. 2013 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн 10.8 хувь нь өсөлт хоцролттой, 1.6 хувь нь тураалтай, 1.0 хувь нь туранхай, 16.7 хувь нь илүүдэл жин ба таргалалттай байна⁵. Үндэсний түвшинд хоол тэжээлийн байдлын үзүүлэлт сайжирсан хэдий ч бүс нутаг, нийгэм эдийн засгийн хувьд ялгаатай байдал байсаар байна. Тухайлбал, 5 хүртэлх насны хүүхдийн дундах өсөлт хоцролтын тархалт баруун бүсэд 19.5 хувь, зүүн бүсэд 13.5 хувь байгаа бол Улаанбаатар хотод 7.1 хувь байна. Амьжиргааны түвшин доогуур өрхийн 5 хүртэлх насны хүүхдийн 25.2 хувь, амьжиргааны түвшин дээгүүр өрхийн хүүхдийн 6.5 хувь өсөлт хоцролттой байна. Бага боловсролтой эхийн хүүхэд, эрэгтэй хүүхэд хоол тэжээлийн дуталд илүү өртөж байна.

Хүн амын дунд ядуурал төдийлэн сайн буураагүй⁵ учраас эдийн засгийн хямрал, хүнсний хомсдол, гамшиг, онцгой байдлын үед хэт мэдрэг чанартай хоол тэжээлийн хурц дутлыг илтгэх (туранхай, тураал) үзүүлэлтүүд огцом нэмэгдэн хүн амын нилээд хэсэг хамрагдах магадлал байсаар байна.

Эхийн сүүгээр хооллолт:

Монголчууд хүүхдээ эхийн сүүгээр хооллодог эртний уламжлалтай. Манай улсын эхийн сүүгээр хооллолтын үзүүлэлт бүс нутаг ба дэлхийн түвшинд сайн гэж үнэлэгддэг ч сүүлийн жилүүдэд буурах хандлагатай болжээ. 6 хүртэлх сартай хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох үзүүлэлт 2000 оноос хойшхи 10 гаруй жилд харьцангуй тогтонги (55-60 хувь) байсан ч, 2013 онд 47 хувьд хүрч буурчээ⁴.

Хүүхдийн нэмэгдэл хоол:

Монголын 6-11 сартай хүүхдийн 98.4 хувь, 25-59 сартай хүүхдийн 99.9 хувь, 12-23 сартай бүх хүүхдүүд ДЭМБ болон Эрүүл мэндийн яамны зөвлөмж (хэмжээ, давтамж)-ийн дагуу хооллож чадахгүй байна. Мөн Монгол хүүхдийн нэмэгдэл хоолны давтамж, нэг удаад идэх хэмжээ хангалтгүйгээс гадна илчлэг ихтэй, шим тэжээл багатай^{6, 7} байна. Зохих давтамжийн дагуу нэмэгдэл хоолоор хооллож байгаа 6-23 сартай хүүхэд 2010 онд 30 хувь, 2013 онд 35 хувь байв^{8, 4}.

Аминдэм бичил бодисын дутал, хангалт, хүнс баяжуулалт:

Хүүхэд, эмэгтэйчүүдийн дунд аминдэм, эрдэс бодисын дутал буурахгүй байна. Тухайлбал, 5 хүртэлх насны хүүхдийн 32.3 хувь нь А аминдэмийн дуталтай,

⁵ "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа – 2013", Урьдчилсан дүн. Үндэсний статистикийн хороо, 2014

⁶ "Монголын эх хүүхдийн хоол тэжээлийн байдал" Үндэсний 3 дугаар судалгааны тайлан, ЭМСЯ, 2004

⁷ Lander R, Enkhjargal TS, Batjargal J et al. (2010) Poor dietary quality of complementary foods is associated with multiple micronutrient deficiencies during early childhood in Mongolia. *Public Health Nutr.* 13, 1304–13.

⁸ "Олон үзүүлэлтэт түүвэр судалгаа – 2010" Үндэсний статистикийн хороо, 2013

21.8 хувь нь Д аминдэмийн дуталтай, 28.5 хувь нь цус багадалттай, 21.4 хувь нь төмрийн дуталтай байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 26.5 хувь нь, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 14.4 хувь нь цус багадалттай, 28.2 хувь нь төмрийн дуталтай, 30 хувь нь Д аминдэмийн дуталтай байна⁹. Монголын 3 хүртэлх насны хүүхдийн 74.4 хувь нь цайр, 56 хувь нь селен болон бусад бичил элементийн дуталтай байна¹⁰. 2013 онд өндөр тунт А аминдэмийн түгээлтэд 6-59 сартай хүүхдийн 82.9 хувь нь хамрагджээ⁴.

Манай улс цус багадалт, аминдэм, бичил бодисын дутлаас сэргийлэх зорилгоор¹¹ 2008 он хүртэл фолийн хүчилтэй төмрийн бэлдмэлийг, 2008-2012 онд олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхчүүд, 6-23 сартай хүүхдэд олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд түгээж байсан. Мөн олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд гурил баяжуулалт 2006-2010 онуудад хийгдэж байв.

Тулгамдаж буй асуудлууд

- Одоо мөрдөгдөж буй “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай” хуулийн зүйл, заалтууд нь хуучирч, бодит амьдрал дээр хэрэгждэггүйгээс хүүхдийг эхийн сүүгээр хооллолтыг дэмжих үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Эх хамгааллын эрх зүйн орчин хангалтгүйн улмаас хөхүүл эх амьдралын хэрэгцээ шаардлагын улмаас ажил, сургуульдаа буцаж орсноор бага насны хүүхдийг хүссэн үед нь хөхүүлэх, хооллох зарчим алдагдахад хүрч байна. Төр, хувийн хэвшилд эх, хүүхдэд ээлтэй орчин үгүйлэгдэж байна.
- Эх, хүүхдийг аминдэм, эрдэс бодисоор хангах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, зорилтот түвшинд хүрэхгүй, эрх зүйн зохицуулалт, санхүүжилт тодорхойгүй байна.
- Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийн хооллолт, асаргаа, бага насны хүүхдийн хооллолтын талаар эцэг эх, асрамжлагчид эрүүл мэндийн ажилтнаас зөвлөгөө өгөх чадавхи хангалтгүй байна.
- Эрүүл мэндийн салбарт олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа тогтмолжоогүй, хүрээ хязгаарлагдмал байна.
- Бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих салбар хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй, мэдээлэл, харилцаа уялдаагүй байна.
- Бага насны хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулахад хувийн хэвшлийн оролцоо хангалтгүй, татан оролцуулах хөшүүрэг алга байна.

Хоёр. Стратегийн зорилго, зорилтууд

Зорилго:

Бага насны хүүхдийн хоол тэжээлээс хамааралт эмгэгийн түвшинг 2020 он гэхэд 2013 онтой харьцуулахад 30 хувиар бууруулах

Стратегийн зорилт 1.

Эх, бага насны хүүхдийн хоол тэжээлтэй холбоотой эрх зүйн орчинг сайжруулах;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1. Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих эрх зүйн орчинг сайжруулах,
2. Эх хамгааллыг дэмжих эрх зүйн орчинг сайжруулах,

⁹ “Эх хүүхдийн хоол тэжээлийн байдал” үндэсний 4 дүгээр судалгааны тайлан. ЭМЯ. 2010

¹⁰ Lander R, Enkhjargal T, Batjargal J et al. (2008) Multiple micronutrient deficiencies persist during early childhood in Mongolia. *Asia Pac J Clin Nutr* 17, 429–40.

¹¹ WHO. *Guideline: Daily iron and folic acid supplementation in pregnant women*. Geneva, World Health Organization, 2012.

3. Хүнснийг баяжуулах, хүүхдийн тэжээллэг нэмэгдэл хоол үйлдвэрлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх,

Хүрэх үр дүн:

Бага насны хүүхдийн эхийн сүүгээр хооллолт, эх хамгааллыг дэмжих, хүнс баяжуулах эрх зүйн орчин сайжирна.

Стратегийн зорилт 2.

Эх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих чиглэлээр эрүүл мэндийн тогтолцоог чадавхжуулах;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1. Анагаахын мэргэжлийн сургуулиудийн төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр дэх бага насны хүүхдийн хооллолтын сэдэв, агуулгыг өргөжүүлэх,
2. Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийн хооллолт, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх эрүүл мэндийн ажилтны мэдлэг, ур чадварыг сайжруулах,
3. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулахад туслах дэмжлэгт хяналтыг тогтмолжуулах,
4. Хүүхэд, эмэгтэйчүүдийг нэн шаардлагатай аминдэм, эрдэс бодисоор тогтвортой хангах,

Хүрэх үр дүн:

Эрүүл мэндийн тогтолцооны бага насны хүүхдийн хоол тэжээлийн тусламж үйлчилгээ, хяналт-шинжилгээ үнэлгээний чадавхи сайжирч, тогтвортой байдал хангагдана.

Стратегийн зорилт 3.

Бага насны хүүхдийг хооллолтыг сайжруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1. Олон нийтийн санаачлагыг түшиглэн бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын хүрээг тодорхойлох,
2. Бага насны хүүхдийг хооллолтыг сайжруулахад олон нийтийн оролцоо, салбар хоорондын түншлэлийг нэмэгдүүлэх,
3. Олон нийтийн санал, санаачлагыг дэмжих, сурталчлах, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх,

Хүрэх үр дүн:

Бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих чиглэлээр олон нийтэд түшиглэсэн санал, санаачлага идэвхжиж, салбар хоорондын хамтын ажиллагаа өргөжинө.

Стратегийн зорилт 4.

Мэдээлэл харилцааны олон төрлийн сувгийг ашиглан бага насны хүүхдийн хооллолтын зөв дадлыг дэмжих, зан үйлийг төлөвшүүлэх;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1. Эрүүл мэндийн байгууллагын ажилтанд зориулсан мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх,
2. Хүн амд чиглэсэн мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх,
3. Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагч нарт чиглэсэн ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлэх,

Хүрэх үр дүн:

Бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн ажилтан, хүн амын бага насны хүүхдийн хооллолтын талаарх мэдлэг, хандлага сайжирч, хүүхдийн хооллолтын зөв дадал төлөвшинэ.

Стратегийн зорилт 5.

Бага насны хүүхдийн нэмэгдэл хоолны чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1. Дотоодын хүнсний үйлдвэрлэл, өрхийн хүнсний ногоо тариалалтыг дэмжих,
2. Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах,

Хүрэх үр дүн:

Хүүхдийн нэмэгдэл хоолны (хүүхдэд зориулсан органик хүнсний) дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, орон нутагт олдоцтой хүнсээр бэлдсэн нэмэгдэл хоолны нэр төрөл олшрон тэжээллэг, аюулгүй нэмэгдэл хоолны чанар, хүртээмж сайжирна.

Стратегийн зорилт 6.

Гамшиг, онцгой байдал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих, хоол хүнсээр хангах тогтолцоог бүрдүүлэх;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1. Гамшигийн үед жирэмсэн, хөхүүл эх, бага насны хүүхдийн хооллолтын тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах чадавхийг нэмэгдүүлэх,
2. ХДХВ-ийн халдвартай эхээс төрсөн хүүхдийн хооллолтын талаар эмч, эмнэлгийн ажилтнуудын мэдлэг чадавхийг дээшлүүлэх,
3. Бага орлоготой, олон хүүхэдтэй өрхийн бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих,

Хүрэх үр дүн:

Гамшиг, онцгой байдлын үед хүүхэд, жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхэд хоол тэжээлийн тусламж үзүүлэх нөөц бүрдэж, чадавхи нэмэгдэнэ.

Гурав. Стратегийн хэрэгжилтэд баримтлах зарчим

Эрүүл мэндийн байгууллага нь өрх гэр, олон нийтэд түшиглэн бага насны хүүхдийн хоол тэжээлийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган ажиллахад анхаарна.

Хүүхэд, тэдний асран хамгаалагчдад яс үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал, газар зүйн байршил, орлого, бие бялдрын байдлыг харгалзахгүйгээр бага насны хүүхдийн хооллолтын мэдээлэл, тусламж үйлчилгээг хүртээмжтэй, жигд хүргэнэ.

Бага насны хүүхдийн хоол тэжээлийн тусламж, үйлчилгээг нотолгоонд тулгуурласан, батлагдсан стандарт, удирдамжийн дагуу үзүүлнэ.

Бага насны хүүхдийн хооллолтын тусламж үйлчилгээ нь дархлаажуулалт, хүүхэд хамгаалал, ХДХВ/ДОХ-оос сэргийлэлт, гэр бүл төлөвлөлтийн үйл ажиллагаатай нягт уялдсан байна.

Судалгаа, үнэлгээний дүгнэлт зөвлөмжинд тулгуурласан, тэргүүн туршлагыг дэлгэрүүлэхэд чиглэсэн бодлого, стандарт, удирдамжийн дагуу үйл ажиллагаа хэрэгжинэ.

Хамтрагч талууд өөрийн үүрэг, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн чадавх, нөөцийн тогтвортой байдлаа хангаж ажиллана.

Стратегийн зорилго, зорилт, чиглэлийг хамтрагч талууд харилцан зөвшөөрч, Засгийн газар болон түншлэгчид үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан байна.

Дөрөв. Стратегийн хэрэгжилтийн зохион байгуулалт, санхүүжилт

Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллана.

Стратегийн хэрэгжилтэд оролцогч талуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх "Нийгмийн эрүүл мэндийн дэд зөвлөл"-ийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

Стратегийн санхүүжилт

Стратегийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- Улсын болон орон нутгийн төсөв
- Эрүүл мэндийг болон үйлдвэрлэлийг дэмжих, нийгмийн хариуцлагын сан
- Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр
- Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр

Тав. Стратегийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

"Эх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих стратеги"-ийг 2015-2020 онд хэрэгжүүлнэ. 2020 онд төгсгөлийн үнэлгээг хийнэ. Үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь "Эх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих стратеги"-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг Засаг даргын тамгын газрын дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн Зөвлөлөөр хэлэлцүүлж, тайланг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ¹².

Стратегийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	2013 оны суурь түвшин (%)	2020 оны зорилтот түвшин (%)	Эх сурвалж
1	Төрсний дараах 1 цагийн дотор ангир уургаа амалсан хүүхдийн эзлэх хувь	71	90	Үндэсний статистикийн хорооны нийгмийн үзүүлэлтийн түүвэр
2	Эхийн сүүгээр дагнан хооллож буй 0-5 сартай хүүхдийн эзлэх хувь	47	70	

¹² Эрүүл мэндийн сайдын 2013 оны 448 дугаар тушаалын дагуу тайлагнана.

3	Хугацаандаа нэмэгдэл хоолонд орсон хүүхдийн эзлэх хувь (6-8 сар)	78	85	судалгаа
4	Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэж буй 6-23 сартай хүүхдийн эзлэх хувь	35	60	
5	Өдөрт 4 ба түүнээс дээш олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж буй 6-23 сартай хүүхдийн эзлэх хувь	52.1	75	Хоол тэжээлийн үндэсний судалгаа
6	Тав хүртэлх насны хүүхдийн дундах тураалын түвшин	1.6	≤ 1.6	Үндэсний статистикийн хорооны нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
7	Тав хүртэлх насны хүүхдийн дундах туранхайн түвшин	1.0	≤ 1.0	
8	Тав хүртэлх насны хүүхдийн дундах өсөлт хоцролтын түвшин	10.8	7.0	
9	Тав хүртэлх насны хүүхдийн дундах илүүдэл жингийн түвшин	16.7	≤ 16.7	
10	Тав хүртэлх насны хүүхдийн дундах таргалалтын түвшин	7.3	≤ 7.3	
11	Тав хүртэлх насны хүүхдийн дундах Д аминдэмийн дутлын тархалт	28	20	Хоол тэжээлийн үндэсний судалгаа
12	Тав хүртэлх насны хүүхдийн дундах А аминдэмийн дутлын тархалт	32.3	25	
13	Тав хүртэлх насны хүүхдийн дундах цус багадалтын тархалт	28	20	
14	Жирэмсэн эмэгтэйн дундах цус багадалтын тархалт	26.5	20	
15	Төрөх насны эмэгтэйн дундах цус багадалтын тархалт	14.4	12	

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны
 07 дугаар сарын 24 өдрийн 325 дугаар
 тушаалын хоёрдугаар хавсралт

“Эх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих стратеги 2015-2020”-ийг
 хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах салбар, хамтрагч байгууллага	Хугацаа
<p><u>Зорилт 1:</u> Бага насны хүүхдийн хоол тэжээлтэй холбоотой эрх зүйн орчинг сайжруулах</p>	<p>Нэг: Хүүхдийг эхийн сүүгээр хооллолтыг дэмжих эрх зүйн орчинг сайжруулах</p>	<p>1. Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталгаажуулах 2. Шинэчлэн найруулсан “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай” хуулийг дагалдан гарах журам, зааврыг боловсруулах 3. Хүүхдийн хооллолтын байдал ба хоол тэжээлтэй холбоотой шалгуур үзүүлэлтийг боловсруулан эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд оруулах 4. Хүүхдийн хооллолтын байдал ба хоол тэжээлтэй холбоотой шалгуур</p>	<p>Шинэчлэн найруулсан хууль Батлагдсан журам, заавар Баталгаажсан шалгуур үзүүлэлт</p>	<p>ЭМСЯ, НЭМХ, ЭХЭМҮТ, МХЕГ, ЭМСЯ, МХЕГ, НЭМХ, ЭХЭМҮТ ЭМСЯ, НЭМХ</p>	<p>2015-2016 2017-2020 2015-2016</p>
			<p>Нийт шинжээчдээс сургалтад хамрагдсан шинжээчдийн тоо, хувь</p>	<p>ЭМСЯ, НЭМХ</p>	

		<p>үзүүлэлтээр ЭМБ-ыг магадлан итгэмжлэх шинжээчдийн сургалт зохион байгуулах</p>			
<p>Хоёр: Эх хамгааллыг дэмжих эрх зүйн орчинг сайжруулах</p>		<p>1. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын эх хамгааллыг дэмжих (183/2000) конвенци, зөвлөмжид (191) нэгдэх асуудлыг шийдвэрлүүлэх</p> <p>2. Хөдөлмөрийн тухай хуулинд бага насны хүүхэдтэй эх хорогдуулсан (1 хүртэл насны хүүхэдтэй эх 2 цаг) цагаар ажиллах зохицуулалтыг нэмэлтээр оруулах</p> <p>3. Ажлын байранд ажилтан эх хүүхдээ хөхүүлэх, асрах эхэд ээлтэй орчинг бүрдүүлэх санал, санаачлагыг өрнүүлэх</p> <p>4. Олон нийтийн газар, орчинд хүүхдийг хөхүүлэх, асрах үйлчилгээ үзүүлэх боломж, нөхцлийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>Конвенцид нэгдсэн тогтоол</p>	<p>Хөдөлмөрийн яам</p>	<p>2015-2018</p>
<p>Гурав: Хүнсийг баяжуулах, хүүхдийн тэжээллэг нэмэгдэл хоол</p>		<p>1. Хүнсийг баяжуулах хуулийн төсөл боловсруулах, өргөн барих, батлуулах</p> <p>2. Хүүхдийн нэмэгдэл хоолны үйлдвэрлэл эрхлэгчдэд</p>	<p>Нэмэлтээр орж, батлагдсан хуулийн зүйл, заалт</p> <p>Санаачлагыг дэмжин хэрэгжүүлж буй байгууллага, аж ахуйн нэгжийн тоо</p> <p>1). Батлагдсан стандарт, журам, шийдвэр.</p> <p>2). Нөхцөл боломжоор хангагдсан үйлчилгээний байгууллагын тоо</p> <p>Батлагдсан хууль</p> <p>Батлагдсан журам, заавар</p>	<p>Хөдөлмөрийн яам, Монголын ажил олгогч эздийн холбоо, МҮХАҮТ, МҮЭХ, Аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллага, Нийслэлийн Засаг дарга, ЗДТГ</p> <p>2015-2018</p> <p>Засгийн газар, ЭМСЯ, ХХААЯ, СЯ</p> <p>ХХААЯ, ЭМСЯ</p>	<p>2016-2017</p> <p>2015-2017</p>

	үйлдвэрлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	төрөөс дэмжлэг үзүүлэх нөхцөл бололцоог судлан, асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах		
--	--------------------------------------	---	--	--

Зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах салбар, хамтрагч байгууллага	Хугацаа
<p>Зорилт 2: Бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих чиглэлээр эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх</p>	<p>Нэг: Анагаахын мэргэжлийн сургуулиудийн төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр дэх Бага насны хүүхдийн хооллолтын сэдэв, агуулгыг өргөжүүлэх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Анагаахын мэргэжлийн сургуулиудын цөм хөтөлбөрт "Бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө" сургалтын хөтөлбөрийг нэмж оруулах 2. Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт "Бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө" сургалтын хөтөлбөрийг нэмж оруулах 3. ХДХВ-ийн халдвартай эхээс төрсөн нярайн хооллолтын удирдамж боловсруулах, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт оруулах 4. "Бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө" сургалтын хөтөлбөрөөр анагаахын боловсрол олгох сургуулийн багш нарт сургалт зохион байгуулах 	<p>Нэмэлтээр орсон сургалтын хөтөлбөр</p> <p>Батлагдсан сургалтын хөтөлбөр</p> <p>Батлагдсан удирдамж, хөтөлбөр</p> <p>Сургагч багшийн тоо, Сургалтын тоо</p> <p>Батлагдсан зөвлөмж</p>	<p>БСШУЯ, ЭМСЯ, АШУУИС, НЭМХ, ЭХЭМҮТ</p> <p>БСШУЯ, ЭМСЯ, АШУУИС, НЭМХ, ЭХЭМҮТ</p> <p>ЭМСЯ, АШУУИС, НЭМХ, ЭХЭМҮТ</p> <p>ЭМСЯ, АШУУИС, НЭМХ, ЭХЭМҮТ</p> <p>ЭМСЯ, АШУУИС, НЭМХ, ЭХЭМҮТ</p>	<p>2018-2020</p> <p>2015-2016</p> <p>2015-2016</p> <p>2016-2018</p> <p>2015-2016</p>
	<p>Хоёр: Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийн хооллолт, бага насны хүүхдийн</p>	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн ажилтнуудад зориулан бага насны хүүхдийн хооллолтын шинэчилсэн зөвлөмжийг боловсруулж, 			

	<p>хооллолтын зөвлөгөө өгөх эрүүл мэндийн ажилтны мэдлэг, ур чадварыг сайжруулах</p>	<p>баталгаажуулах</p> <p>2. Бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх ур чадвар эзэмшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах (бус)</p> <p>3. Бага насны хүүхдийн хооллолтын талаарх зайн сургалтыг эрүүл мэндийн ажилтнуудад зохион байгуулах</p> <p>4. Эрүүл мэндийн туслах ажилтан, сайн дурын ажилтанг "Бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх" сургалтад хамруулах</p> <p>5. Бага насны хүүхдийн хооллолтын "Дэмжлэгт хяналт, тандалт"-ын гарын авлага боловсруулж, түгээх</p> <p>6. Бага насны хүүхдийн хооллолтын дэмжлэгт хяналт, тандалтыг тодорхой хугацаанд тогтмол хийх</p> <p>1. "Хүүхдийг ангир уургаар амлуулахын ач холбогдол" чиглэлээр жирэмсэн эмэгтэй, түүний гэр бүлийн гишүүдийг, "Хүүхдийг хөхүүлэхэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх" чиглэлээр</p>	<p>Сургалтын тоо, сургалтад хамрагдсаны тоо</p> <p>Сургалтын тоо, сургалтад хамрагдсан ЭМА-ы тоо</p> <p>Сургалтын тоо, сургалтад хамрагдсан ЭМ-ийн СДА-ы тоо</p> <p>Гарын авлага</p> <p>Дэмжлэгт хяналт тандалтын тоо</p> <p>Сургалтын тоо, сургалтад хамрагдсан ЭМ-ийн СДА-ы тоо</p>	<p>Аймаг, нийслэлийн ЭМГ, АШУУИС, НЭМХ, ТББ</p> <p>Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭМХ, ТББ</p> <p>НЭМХ, ЭХЭМҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ, ТББ</p> <p>ЭМСЯ, НЭМХ, Аймаг, нийслэлийн ЭМГ, ТББ</p> <p>Аймаг, нийслэлийн ЭМГ, Сум, Өрхийн эрүүл мэндийн төв, ТББ</p>	<p>2016-2020</p> <p>2016-2020</p> <p>2016-2020</p> <p>2016-2020</p> <p>2016-2020</p>
	<p>Гурав: Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын ажилтнуудын Бага насны хүүхдийн</p>				

	<p>хооллолтын зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах дэмжлэгт хяналтыг тогтмолжуулах</p>	<p>бага эмч, сувилагч, нийгмийн ажилтнууд, эрүүл мэндийг дэмжигч идэвхтнүүдийг сургах</p> <p>2. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж, түгээх</p> <p>3. Жирэмсэн эмэгтэйчүүдэд хяналтын хугацаанд сургалт явуулах, сургалтын материал аргачлалаар хангах, эхчүүдийн амрах байранд практик сургалтыг тогтмол явуулах,</p> <p>4. Хөхний сүү татрах, сүүгүй болох шалтгааныг судалж, сүүний гарцыг нэмэгдүүлэх эмийн бус эмчилгээний шинэ арга, технологийг нэвтрүүлэх</p> <p>5. Өсвөр насны эхээс төрсөн, ХДХВ-ийн халдвартай эхээс төрсөн хүүхдийг хооллох, зөвлөгөө өгөх арга барилд эрүүл мэндийн ажилтнуудыг сургах</p> <p>6. Эхийн сүүгээр хооллолтын талаарх зөвлөгчийг (Lactation counselor) бэлтгэх, үндэсний сүлжээг бий</p>	<p>Сургалтын хөтөлбөр, гарын авлагын тоо</p> <p>Сургалтын тоо, сургалтын материал</p> <p>Батлагдсан эмийн бус эмчилгээний аргачлал</p> <p>Сургагдсан ЭМА-ны тоо</p> <p>Зөвлөгчийн тоо</p>	<p>ЭМСЯ, Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭМХ</p> <p>Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМН, Өрх, сумын эрүүл мэндийн төв, ТББ</p> <p>ЭМСЯ, АУХ, НЭМХ, ЭХЭМҮТ</p> <p>ЭМСЯ, ЭХЭМҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭМХ, ТББ</p> <p>ЭМСЯ, ЭХЭМҮТ, НЭМХ, ЭМГ-ууд, ТББ</p>	<p>2016</p> <p>2015-2020</p> <p>2016-2020</p> <p>2017-2019</p> <p>2017-2020</p>
--	--	---	---	--	---

	<p>Дөрөв: Хүүхэд, эмэгтэйчүүдийн дундах аминдэм, эрдсийн дутал 5%-иас буурах хүртэл тэднийг нэн шаардлагатай аминдэм, эрдэс бодисоор тогтвортой хангах</p>	<p>болгох</p> <ol style="list-style-type: none"> 6-23 сартай хүүхдийг олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлээр хангах 6-59 сартай хүүхдийг өндөр тунт А аминдэмээр хангах 0-36 сартай хүүхдийг өндөр тунт Д аминдэмээр хангах Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийг олон найрлагат бичил тэжээлийн (фолийн хүчил бүхий төмрийн бэлдмэл, кальци) бэлдмэлээр хангах Зорилтот бүлгийн хүүхэд, эмэгтэйчүүдийг баяжуулсан эсвэл аминдэм, эрдэс бодисоор баялаг хүнсээр хангах 	<p>Хангалтад хамрагдсан хүүхдийн тоо, хувь</p>	<p>ЭМСЯ, СЯ</p>	<p>2015-2020</p>
			<p>Хангалтад хамрагдсан жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийн тоо</p>	<p>ХАХНХЯ</p>	<p>2015-2020</p>
			<p>Дэмжлэг авсан зорилтот бүлгийн хүүхэд, эмэгтэйчүүдийн тоо</p>		

Зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах салбар, хамтрагч байгууллага	Хугацаа
Зорилт 3: Нялх, бага насны хүүхдийн хооллолтыг сайжруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Нэг: Олон нийтийн санаачлагыг түшиглэн БНХХ-ыг дэмжих чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын хүрээг тодорхойлох	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн салбарт олон нийтийн санаачлагыг түшиглэн хийж гүйцэтгэх ажлын хүрээг тодорхойлж баталгаажуулах 2. Олон нийтийн санаачлагад түшиглэсэн бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг бий болгох, хэрэгжүүлэх 	Батлагдсан ажлын хүрээ, жагсаалт	ЭМСЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, НЭМХ	2016
Хоёр: Олон нийтийн оролцоо, түншлэлийг нэмэгдүүлэх		<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлагын Аймаг, орон нутгийн Засаг даргатай хийх үр дүнгийн гэрээнд олон нийтийн санаачлагад түшиглэн хүүхдийн хоол тэжээлийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх үзүүлэлтийг тусгах 2. Эхчүүдийн бүлэг, сайн дурын ажилтан, дэмжлэгт бүлэг зэрэг олон нийтийн 	Орон нутгийн Засаг даргын дэмжлэгтэй байгуулагдсан Бага насны хүүхдийн хооллолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон нийтэд түшиглэсэн санал, санаачлагын тоо, Арга хэмжээний тоо, үзүүлэлт	ЭМСЯ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, ЭМГ	2016-2020
			Хэвлэгдсэн гарын авлага	НЭМХ, ЭХЭМҮТ, Аймаг, Нийслэлийн ЭМГ, ТББ	2016

	<p>Гурав: Олон нийтийн санал, санаачлагыг дэмжих, сурталчлах, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх</p>	<p>бүлэгт зориулсан гарын авлагыг боловсруулах</p> <p>1. Олон нийтэд түшиглэсэн санаачлагыг дэмжих, сурталчлах, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх</p>	<p>Аймгийн засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн тоо</p>	<p>Аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал</p>	<p>2015</p>
--	--	--	--	--	-------------

Зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах салбар, хамтрагч байгууллага	Хугацаа
Зорилт 4: Мэдээлэл харилцааны олон төрлийн сувгийг ашиглан нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөв дадлыг дэмжих, зан үйлийг төлөвшүүлэх	Нэг: Эрүүл мэндийн байгууллагын ажилтанд зориулсан мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Бага насны хүүхдийн хооллолтын дадал, зан үйлийн талаар судалгаа хийх, зөвлөмж гаргах 2. Телевиз, LCD видео хичээлийг ашиглан явуулах сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг холбогдох ЭМБ-уудад тогтмолжуулах 3. Сум, өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийг түшиглэн эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, нэмэгдэл хоол бэлдэх талаар оролцогч төвтэй сургалтыг тогтмол зохион байгуулж, хэвшүүлэх 	Судалгааны тайлан, зөвлөмж	ЭМСЯ, НЭМХ, Аймаг, нийслэлийн ЭМГ	2015
			Телемедицин, онлайн шугам ашигласан сургалт, мэдээлэл сурталчилгааны тоо	НЭМХ, ЭХЭМҮТ, ЭМХТ, Аймаг, нийслэлийн ЭМГ, Дүүргийн ЭМН, Сум, өрхийн эрүүл мэндийн төв, ТББ	2015-2020
	Хоёр: Хүн амд чиглэсэн мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Жирэмсэн эмэгтэй, хөхүүл хүүхэдтэй эхийн хооллолтын талаарх санамж, гол мэдээллийг (key message) боловсруулж, түгээх 2. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих үндэсний аяныг тогтмол зохион байгуулж 	Санамжийн тоо	ЭМСЯ, НЭМХ, Аймаг, Нийслэлийн ЭМГ	2015
			Үндэсний аяны хүрээнд хийгдсэн ажлын тайлан	Аймаг, нийслэлийн ЭМГ, Дүүргийн ЭМН, Сум, өрхийн эрүүл	2015-2020

	хэвших	Өдөрлөг, тэмцээн, уулзалт, олон нийтийн арга хэмжээний тоо	мэндийн төв, ТББ
	<p>3. Эцэг эх, асран хамгаалагчдын дунд эхийн сүүгээр хооллолт, нэмэгдэл хоолны ач холбогдлыг сурталчлах өдөрлөг, тэмцээн, ярилцлага, уулзалт зэрэг олон нийтийг оролцоог идэвхижүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах</p>		
	<p>4. Орон нутагт эхчүүдийн дэмжих бүлэг байгуулах, тэднийг бага насны хүүхдийн хооллолтын талаарх туршлагаа солилцоход бүх талын дэмжлэг үзүүлэх</p>	<p>Орон нутаг дахь тогтмол үйл ажиллагаатай БНХХ-ыг дэмжих бүлгийн тоо</p>	<p>Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, Аж ахуйн нэгж, хувийн хэвшил, ТББ</p> <p>2015-2020</p>
	<p>5. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих гол (түлхүүр) мэдээллийг боловсруулж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээх</p>	<p>Мэдээллийн сувгаар цацагдсан тоо</p>	<p>ЭМСЯ, НЭМХ, Аймаг, нийслэлийн ЭМГ</p> <p>2015-2020</p>
	<p>6. Олон нийтийн мэдээллийн сувгууд (facebook, twitter), гар утас ба суурин холбоог ашиглан Бага насны хүүхдийн хооллолтын талаар мэдээлэл сурталчилгаа хийх</p>	<p>Олон нийтийн мэдээллийн сувгаар цацагдсан Бага насны хүүхдийн хооллолтын талаарх мэдээлэл, сурталчилгааны тоо</p>	<p>Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ТББ, Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл</p> <p>2015-2020</p>

	7. Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эх, тэдний гэр бүлийн гишүүдэд хүүхдийн нэмэгдэл хоолыг хэрхэн зөв бэлтгэх, нэмэгдэл хоолонд зөв оруулах арга барилд сургах санамж, товхимол боловсруулж, хэвлүүлэн, түгээх	Санамж, товхимол, гарын авлагын тоо	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ	2015-2020
	8. Зөв хооллолтыг дэмжиж, амжилттай хэрэгжүүлж буй эцэг эх, ЭМА-ныг сурталчлах, алдаршуулах	Санал, санаачлагын тоо	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ	2015-2020
Гурав: Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагч нарт чиглэсэн ухуулга нөлөөллийг эрчимжүүлэх	1. Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний импортод хяналт тавих, бүртгэл мэдээллийн тогтолцоог сайжруулах ухуулга нөлөөллийн арга хэмжээг бүх түвшинд явуулах	Ухуулга нөлөөллийн арга хэмжээний тоо	ЭМСЯ, ШӨХТГ, МХЕГ, Аймаг нийслэлийн МХГ, ЭМГ, Гаалийн ерөнхий газар, НЭМХ, ТББ	2015-2020
	2. Эхэд ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэсэн мэдээллийг үйлдвэр, компаний эздэд хүргэх	Эхэд ээлтэй орчин бүрдүүлсэн аж ахуйн нэгжийн тоо	ЭМСЯ, ХЯ, ХАХНХЯ, аймаг, Нийслэлийн ЗДТГ, ЭМГ, Нийгмийн халамжийн газар, МХАУТ	2015-2020
	3. Хүүхдэд зориулсан хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хувийн хэвшил, хандивлагч орнууд, олон улсын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх ухуулга,	Орон нутаг ба дотоод үйлдвэрлэсэн хүүхдэд зориулсан эрүүл хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн тоо	ЭМСЯ, ХХААЯ, МХЕГ, МХАУТ, НЭМХ, аймаг, нийслэлийн ЭМГ, Хүнсчдийн холбоо, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид	2015-2020

			нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах		
--	--	--	--	--	--

Зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах салбар, хамтрагч байгууллага	Хугацаа
Зорилт 5: Хүүхдийн нэмэгдэл хоолны чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх	Нэг: Дотоодын хүнсний үйлдвэрлэл, өрхийн хүнсний ногоо тариалалтыг дэмжих	<ol style="list-style-type: none"> Хүүхдийн нэмэгдэл хоолны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах Хүүхдийн нэмэгдэл хоолны жор, технологи, стандартыг шинэчлэн боловсруулах, баталгаажуулах Хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, технологийн туршилт судалгааг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих Аймаг, дүүргийн түвшинд хүүхдийн нэмэгдэл хоолны үйлдвэрлэл, худалдааны цэг байгуулах Орон нутгийн түвшинд өрх бүр хүлэмжийн ногоо тариалах, сүү цагаан идээ бэлтгэх, үүнийгээ ашиглан хүүхдэд тохирсон хоол хүнсийг өөрсдөө бэлтгэх 	<p>Уулзалт, зөвлөгөөний тоо</p> <p>Батлагдсан жор, технологи, стандартын тоо</p> <p>Хүүхдэд зориулсан хүнсний шинэ бүтээгдэхүүний жор, технологийн тоо</p> <p>Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн нэмэгдэл хоолны үйлдвэрлэл, худалдааны цэгийн тоо</p> <p>Хүлэмжиндээ ногоо, жимс тариалдаг бага насны хүүхэдтэй өрхийн тоо</p>	ЭМСЯ, ХХААЯ	2015
				ЭМСЯ, ХХААЯ, НЭМХ, СХЗГ, ШУТИС	2016-2017
				ЭМСЯ, ХХААЯ, БСШУЯ, СЯ, ШУТИС, НЭМХ, САМО институт,	2017-2019
				Аймаг, нийслэлийн ЗДТГ, Хувийн хэвшил	2015-2020
				Аймаг, нийслэлийн ЗДТГ, Хувийн хэвшил	2015-2020

		зэрэг санал санаачлагыг дэмжих			
		6. Орон нутагт олдоцтой хүнсний бүтээгдэхүүн ашиглан тэжээллэг, аюулгүй нэмэгдэл хоолны жор зохион бүтээх аян өрнүүлэх	Хүүхдийн нэмэгдэл хоолны нэр төрөл	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, Хувийн хэвшил, ШУТИС, НЭМХ	2015-2020
		7. Өрхийн нөхцөлд аминдэм, бичил бодисоор баялаг нарийн ногоо тариалалтыг өргөжүүлэх аян өрнүүлэх	Нарийн ногоо тариалдаг (хүлэмжтэй) өрхийн тоо	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, Хувийн хэвшил	2015-2020
	Хоёр: Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах	1. Хүүхдэд зориулсан импортын хүнс, хоолны эрсдлийг үнэлэх зөвлөл, бүртгэл мэдээллийн сан байгуулах	Эрсдлийг үнэлгээний зөвлөл, Мэдээллийн сан байгуулагдсан байх	ЭМСЯ, ХХААЯ, МХЕГ, МУХАУТ	2015-2020

Зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах салбар, хамтрагч байгууллага	Хугацаа
<p><u>Зорилт 6:</u> Гамшиг, онцгой байдал, хүнд нөхцөлийн үед нялх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих, хоол хүнсээр хангах тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>Нэг. Гамшгийн үеийн Бага насны хүүхдийн хооллолтын тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах</p>	<p>1. Гамшгийн үеийн Бага насны хүүхдийн хооллолтын удирдамж, заавар, зөвлөмж боловсруулах, батлуулах</p>	<p>Батлагдсан гамшгийн үеийн бэлэн байдлын удирдамж, заавар, зөвлөмж</p>	<p>ЭМСЯ, НЭМХ, ЭХЭМҮТ, ОБЕГ</p>	<p>2015</p>
		<p>2. Гамшгийн үеийн Бага насны хүүхдийн хооллолтын байдлыг үнэлэх хурдавчилсан үнэлгээний аргачилсан зөвлөмжийг боловсруулах</p>	<p>Гамшгийн үеийн хоол тэжээлийн байдлын хурдавчилсан үнэлгээний аргачилсан зөвлөмж батлагдсан байх</p>	<p>ЭМСЯ, НЭМХ, ЭХЭМҮТ, ОБЕГ</p>	<p>2015</p>
		<p>3. Гамшгийн үеийн Бага насны хүүхдийн хооллолтын тусламж үйлчилгээний талаар эрүүл мэндийн ажилтнуудыг сургах</p>	<p>Сургалтын тоо, сургалтад хамрагдсан ЭМА-ы тоо</p>	<p>ЭМСЯ, НЭМХ, ЭХЭМҮТ, ОБЕГ</p>	<p>2015</p>
		<p>4. Гамшгийн үед нэн шаардлагатай хоол, аминдэм, эрдэс бодисын бэлдмэлийн нөөцийг бүрдүүлэх, нөөцийн зардлыг улсын төсвөөс гаргадаг байх</p>	<p>Нөөцийн бүрдүүлэлт, батлагдсан улсын төсвийн хэмжээ</p>	<p>ЭМСЯ, ОБЕГ</p>	<p>2015-2020</p>
<p>Хоёр: ХДХВ/ДОХ-ын халдвартай эхээс төрсөн</p>	<p>1. ХДХВ/ДОХ-ын халдвартай эхээс төрсөн хүүхдийг хооллох талаар олон улсын</p>	<p>ХДХВ/ДОХ-ын халдвартай эхээс төрсөн хүүхдийг</p>	<p>ХДХВ/ДОХ-ын халдвартай эхээс төрсөн хүүхдийг</p>	<p>ЭМСЯ, НЭМХ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ</p>	<p>2015-2016</p>

	<p>НЯЛХСЫН ХОЛЛОЛТЫГ ЗӨВ ЧИГЛҮҮЛЭХ</p>	<p>удирдамжийг өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж, холбогдох байгууллага зорилтот бүлэгт тараах, удирдамжийг баталгаажуулах</p> <p>2. Эрүүл мэндийн анхан шатны болон бүх шатны амаржих газруудын ажилтнуудыг ХДХВ/ДОХ-ын халдвартай эхээс төрсөн хүүхдийн хооллолтын талаар сургалтанд хамруулах</p> <p>3. ХДХВ/ДОХ-ын халдвартай эхээс төрсөн нялхсын хоол тэжээлийн зардлыг нийгмийн халамжийн сангаас хангах тогтолцоо бүрдүүлэх</p>	<p>хооллолтын удирдамж батлагдсан байх</p>	<p>ЭМСЯ, НЭМХ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ЭМХТ</p> <p>2015-2020</p>	
<p>Гурав: Бага орлоготой, олон хүүхэдтэй өрхийн БНХХ-ыг дэмжих</p>	<p>1. Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн нялх, бага насны хүүхдийн хоол тэжээлийн дэмжлэгийг (хүнсний дэмжлэг, хүнсний эрхийн бичиг) үргэлжлүүлэх</p>	<p>Дэмжлэг хамрагдаж буй нялх, бага насны хүүхдийн тоо</p>	<p>Батлагдсан журам</p>	<p>ЭМСЯ, ХАХНХЯ, Аймгуудын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал</p> <p>2016-2020</p>	<p>ХАХНХЯ, Аймгуудын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал</p> <p>2016-2020</p>